



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2016 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/9/

Улаанбаатар хот

"Дээлтэй монгол наадам-2016"
арга хэмжээнд оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хориндолоодугаар Хуралдааны 27/01 дүгээр тогтоол ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монголчуудын уламжлалт соёл түүний дотор үндэстэн ястны дээл хувцас, ардын урлагийн биет болон биет бус өвийг гадаад, дотоодод сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилготой "Дээлтэй Монгол Наадам-2016" арга хэмжээнд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хороодын Иргэдийн нийтийн Хурлын дарга нар, Ажлын албаны албан хаагчдыг 2016 оны 07 дугаар сарын 10-ны өдөр оролцуулсугай.

2. "Дээлтэй Монгол Наадамд-2016" оролцох зардлыг хавсралтаар баталж, зардал 3,345,000 /гурван сая гурван зуун дөчин таван мянга/ төгрөгийг төвлөрсөн арга хэмжээний зардлаас гаргахыг Ажлын албаны дарга /П.Цэцэгмаа/, Нягтлан бодогч /Б.Батзаяа/ нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.ДЭЛГЭРБАТ

Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын 2016 оны 07 сарын 07-ны өдрийн
5/9 дугаар захирамжийн
хавсралт

"Дээлтэй монгол" төсөв

№	Гүйлгээний утга	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Тайз, хөгжим түрээс	өдөр	1	1,250,000	1,250,000
2	Урлагын тоглолт	ш	1	1,100,000	1,100,000
3	Хувцас түрээс	ш	10	50,000	500,000
4	Хоолны зардал	хүн	55	9,000	495,000
	Нийт мөнгөн дүн				3,345,000

---oo000oo---